



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/083/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mnp
Эрдэнэбулган хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг
Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 127
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хотонт сумын Эрүүл мэндийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй 4,480.9 мянган төгрөг,
- Аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан " Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй
- Эм боох бараа материалын үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ авч ажиллаагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй 60,573.4 мянган төгрөг,
- Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой хөрөнгөд элэгдэл тооцоогүй 12,597.0 мянган төгрөгийн зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 18.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.2, 16.5.3, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дахь заалтууд, Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалын хавсралтыг зөрчсөн иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлын онцлог хэсэг

Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2950 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 23,650.1 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,534,884.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 40,780.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,482,979.1 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 85,544.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 16,882.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн газраас 4,531.2 мянган төгрөгийн, аймгийн ЗДТГ-аас 3,200.0 нийт 24,614.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Эрүүл мэндийн газраас 31,170.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 78.9 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>257,932,378.29</u>	<u>173,827,763.36</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,489.23	85,544,312.54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,489.23	85,544,312.54
3121	Төгрөг	142,489.23	85,544,312.54
31211	Төрийн сангийн харилцах	142,489.23	85,544,312.54
33	АВЛАГА	203,814,795.41	23,650,115.45
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	203,814,795.41	23,650,115.45
35	БАРАА МАТЕРИАЛ	53,975,093.65	64,633,335.37
351	Түүхий эд материал	38,093,123.92	58,381,035.37
35110	Тусгай зориулалттай материал	-	238,087.10
35130	Эм боох материал	38,093,123.92	58,142,948.27
354	Хангамжийн материал	15,881,969.73	6,252,300.00
35410	Бичиг хэргийн материал	120,600.00	274,800.00
35420	Аж ахуйн материал	15,761,369.73	3,097,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,880,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>495,934,270.16</u>	<u>436,238,701.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	495,934,270.16	436,238,701.43
392	Биет хөрөнгө	478,856,270.16	419,160,701.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	260,792,900.33	260,792,900.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(68,094,648.62)	(74,783,935.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,557,150.00	156,328,925.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,045,483.34)	(33,181,663.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	271,263,883.43	223,914,586.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(115,546,901.99)	(120,679,180.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,404,098.00	41,362,776.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,624,519.65)	(39,218,499.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,500,000.00	13,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,350,208.00)	(8,875,208.00)
393	Биет бус хөрөнгө	17,078,000.00	17,078,000.00
39301	Програм хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(385,000.00)	(385,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,078,000.00	17,078,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>753,866,648.45</u>	<u>610,066,464.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>26,440,570.00</u>	<u>9,858,068.29</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,440,570.00	9,858,068.29
413	Өглөг	26,440,570.00	9,858,068.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	260,068.29
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	24,055,470.00	9,598,000.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	727,426,078.45	600,208,396.67
51	Засгийн газрын хувь оролцоо	727,426,078.45	600,208,396.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,988,298.21	396,988,298.21
51101	Өмч: - төрийн	396,988,298.21	396,988,298.21
512	Хуримтлагдсан үр дүн	324,542,995.56	197,325,313.78
51210	Өмнөх үеийн үр дүн	324,542,995.56	324,542,995.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	(127,217,681.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,894,784.68	5,894,784.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	753,866,648.45	610,066,464.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,287,380,199.40	1,434,402,102.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,500,000.00	38,902,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,500,000.00	38,902,220.00
120017	Үнэ төлбөргүй ҮХ		7,731,286.07
120018	Үнэ төлбөргүй БМ		31,170,933.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,283,880,199.40	1,395,499,882.10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	46,240,051.40
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	46,240,051.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,956,000.00	40,780,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,956,000.00	40,780,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,262,924,199.40	1,308,479,830.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,262,924,199.40	1,308,479,830.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,240,810,367.96	1,559,751,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,240,810,367.96	1,559,751,034.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,239,542,333.84	1,510,011,472.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	795,309,458.24	963,850,501.58
210101	Үндсэн цалин	444,497,505.86	461,974,038.79
210102	Нэмэгдэл	273,036,382.77	398,759,366.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,187,000.00	26,552,000.00
210104	Урамшуулал	73,588,569.61	76,565,096.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,766,986.89	119,027,990.29
210201	Тэтгэврийн даатгал	69,665,386.89	82,697,152.94
210202	Тэтгэмжийн даатгал	7,116,400.00	9,857,127.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,557,700.00	5,599,937.99
210204	Ажилгүйдлийн даатгал	3,644,700.00	4,829,632.86
210205	Эрүүл мэндийн даатгал	13,782,800.00	16,044,138.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,411,771.98	18,836,438.97

210301	Гэрэл, цахилгаан	7,090,965.97	7,318,438.97
210302	Түлш, халаалт	10,070,806.01	11,268,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	88,080,500.00	89,812,393.73
210401	Бичиг хэрэг	13,605,800.00	9,331,040.00
210402	Тээвэр, шатахуун	45,840,200.00	27,656,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,411,200.00	9,690,984.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,587,000.00	8,603,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,636,300.00	21,616,600.00
210408	Бараа материал акталсны зардал	-	12,913,869.73
2105	Нормативт зардал	126,975,392.34	172,345,208.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,730,092.34	118,928,408.48
210502	Хоол, хүнс	31,020,000.00	34,321,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,225,300.00	19,095,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,380,000.00	25,177,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	950,000.00	2,470,000.00
210604	Урсгал засвар	5,430,000.00	22,707,600.00
2107	Томилот, зочны зардал	2,844,000.00	5,210,000.00
210702	Дотоод албан томилот	2,844,000.00	5,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,077,100.00	26,852,335.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,714,600.00	24,736,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	183,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	353,385.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	79,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,697,124.39	88,899,004.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,570,000.00	6,458,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,127,124.39	82,441,004.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,268,034.12	49,739,561.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	42,456,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	42,456,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,268,034.12	7,283,561.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,268,034.12	7,283,561.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,569,831.44	(125,348,931.90)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,868,749.88
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,868,749.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,868,749.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	46,569,831.44	(127,217,681.78)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,114,060,718.99	1,575,664,561.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,110,560,718.99	1,575,664,561.49
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	46,240,051.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	46,240,051.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,956,000.00	40,780,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,956,000.00	40,780,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,089,604,718.99	1,488,644,510.49
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,089,604,718.99	1,488,644,510.49
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,141,209,293.35	1,473,829,838.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,141,209,293.35	1,473,829,838.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,139,941,259.23	1,424,090,277.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	790,563,943.25	963,850,501.18
210101	Үндсэн цалин	439,751,990.87	461,974,038.79
210102	Нэмэгдэл	273,036,382.77	398,759,366.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,187,000.00	26,552,000.00
210104	Урамшуулал	73,588,569.61	76,565,096.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,599,891.10	118,767,922.40
210201	Тэтгэврийн даатгал	76,498,291.10	82,697,152.94
210202	Тэтгэмжийн даатгал	7,116,400.00	9,597,060.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,557,700.00	5,599,937.99
210204	Ажилгүйдлийн даатгал	3,644,700.00	4,829,632.86
210205	Эрүүл мэндийн даатгал	13,782,800.00	16,044,138.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,340,965.88	21,716,438.57
210301	Гэрэл, цахилгаан	7,090,965.97	7,318,438.57
210302	Түлш, халаалт	10,999,999.91	14,148,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,818,700.00	77,523,224.00
210401	Бичиг хэрэг	9,064,700.00	11,256,640.00
210402	Тээвэр, шатахуун	38,784,000.00	34,712,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,073,300.00	10,078,184.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,296,700.00	11,067,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,600,000.00	10,408,400.00
2105	Нормативт зардал	109,277,159.00	169,527,656.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,044,359.00	113,678,856.00
210502	Хоол, хүнс	29,700,000.00	34,503,800.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,532,800.00	21,345,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,184,500.00	32,664,200.00
210604	Урсгал засвар	10,184,500.00	32,664,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,844,000.00	5,210,000.00
210702	Дотоод албан томилолт	2,844,000.00	5,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,077,100.00	28,372,335.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,714,600.00	26,256,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	183,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	353,385.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	79,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,235,000.00	6,458,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,235,000.00	6,458,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,268,034.12	49,739,561.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	42,456,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	42,456,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,268,034.12	7,283,561.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,268,034.12	7,283,561.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(27,148,574.36)	101,834,723.31
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,792,000.00	16,432,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,792,000.00	16,432,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,792,000.00	16,432,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,792,000.00	16,432,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(16,792,000.00)	(16,432,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(43,940,574.36)	85,401,823.31
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,489.23
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,489.23	85,544,312.54

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	324,542,995.56	727,426,078.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	324,542,995.56	727,426,078.45

C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	324,542,995.56	727,426,078.45
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	324,542,995.56	727,426,078.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	324,542,995.56	727,426,078.45
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(127,217,681.78)	(127,217,681.78)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	197,325,313.78	600,208,396.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,731,164,100.00	1,482,979,177.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,731,164,100.00	1,473,296,277.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,685,348,100.00	1,430,840,277.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,147,248,100.00	967,941,183.49
210101	Үндсэн цалин	804,518,900.00	461,974,038.79
210102	Нэмэгдэл	141,449,000.00	406,065,048.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,496,300.00	23,337,000.00
210104	Урамшуулал	178,783,900.00	76,565,096.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,401,700.00	114,677,239.69
210201	Тэтгэврийн даатгал	97,950,700.00	75,391,470.23
210202	Тэтгэмжийн даатгал	11,862,800.00	9,597,060.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,931,300.00	8,814,937.99
210204	Ажилгүйдлийн даатгал	5,931,300.00	4,829,632.86
210205	Эрүүл мэндийн даатгал	23,725,600.00	16,044,138.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,300,000.00	21,716,438.97
210301	Гэрэл, цахилгаан	7,300,000.00	7,318,438.97
210302	Түлш, халаалт	9,200,000.00	14,148,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	89,448,800.00	77,709,224.00
210401	Бичиг хэрэг	13,624,400.00	11,256,640.00
210402	Тээвэр, шатахуун	42,396,300.00	34,712,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,556,100.00	10,078,184.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,272,000.00	11,067,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,600,000.00	10,594,400.00
2105	Нормативт зардал	171,175,900.00	169,527,656.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,700,900.00	113,678,856.00
210502	Хоол, хүнс	34,520,400.00	34,503,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,954,600.00	21,345,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,289,400.00	39,228,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,161,900.00	6,564,000.00
210604	Урсгал засвар	29,127,500.00	32,664,200.00
2107	Томилолт, зочны зардал	15,464,000.00	5,210,000.00
210702	Дотоод албан томилолт	15,464,000.00	5,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,728,000.00	28,372,335.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,213,500.00	26,256,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,135,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	183,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	873,900.00	353,385.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	850,800.00	79,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,292,200.00	6,458,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,292,200.00	6,458,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,816,000.00	42,456,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,816,000.00	42,456,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,456,000.00	42,456,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,682,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	9,682,900.00
223001	Бусад хөрөнгө	-	9,682,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,575,806,961.49	1,568,381,000.46
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,780,000.00	33,496,438.97
132001	Орон нутгийн төсвөөс	40,780,000.00	33,496,438.97
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,534,884,561.49	1,534,884,561.49
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,534,884,561.49	1,534,884,561.49
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,489.23
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		85,544,312.54
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	23.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100,897.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд 22,546.4 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

Тайлант онд санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 4 нэр төрлийн 5.9 сая төгрөгийн актлагдсан хөрөнгөд элэгдлийг хасагдах элэгдлээр нөхөн тооцож алдааг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

залруулсан, санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгө, орлого үр дүнгийн тайланд орлого дутуу бүртгэсэн, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө дутуу бүртгэсэн, аклаж устгасан хөрөнгийн гарз бүртгээгүй зэрэг 22,546.4 мянган төгрөгийн алдааг холбогдох дансдад залруулан бүртгүүлэв.

Аудитаар залруулагдаагүй 78,351.5 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 78,351.5 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 15,876.6 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох авто машины сэлбэг, авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан 700.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар”-т Хэрэглүүрийн гуравт “Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт “Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардалын тодорхойлолт”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

5.2 Албан шаардлага

5.2.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 4,480.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2. Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээ болон гэрээний хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ

5.2.3. Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэнээс эм боох материалын үлдэгдэл өндөр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, эм боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авсанаа эхэлж зарлагдах аргыг хэрэглээгүй, эм боох материалын тооллого тооцоо хийж акт үйлдээгүйтэй холбоотой 60,573.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”:, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 “Бараа материал”-ын дагуу бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

5.3.1 Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 12 нэр төрлийн 12,597.0 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтын 10 дугаар зүйлийн 10.24-д “Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ”, 10.26--д “Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа тайлангийн хугацаанд дээрх хөрөнгүүдийн элэгдлийг орлогод хүлээн авсан онуудаас эхлэн нөхөж тооцон холбогдох данс бүртгэлд залруулга хийх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 4 нэр төрлийн 5.9 сая төгрөгийн актлагдсан хөрөнгөд элэгдлийг хасагдах элэгдлээр нөхөн тооцож алдааг залруулсан, санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгө, орлого үр дүнгийн тайланд орлого дутуу бүртгэсэн, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө дутуу бүртгэсэн, аклаж устгасан хөрөнгийн гарз бүртгээгүй зэрэг 22,546.4 мянган төгрөгийн алдааг холбогдох дансад залруулан бүртгүүлэв.	1	22,546.4			1	22,547	1	22,547		
Нийт дүн	1	22,546.4			1	22,547	1	22,547		

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй		4,480.90				4,480.90		
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,	1	0.00			1	0.00		
Эм боох бараа материалын үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо	1	60,573.40			1	60,573.40		

хийж актаар баталгаажуулаагүй,								
Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	700.00	1	700.00				
Санхүүгийн программд үндсэн хөрөнгө бүртгэхдээ ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 39 нэр төрлийн 42.5ая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй,	1	12,597.0					1	12,597.0
Дүн	4	78,351.30	1	700	2	65,054.30	1	12,597.0